



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот


Монголчуудын өв соёлын “Даншиг наадам  
хүрээ цам” наадам зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн “Даншиг наадам хүрээ цам” зохион байгуулах тухай А/717 дугаар захирамж, 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн “Хөрөнгө гаргах тухай” А/859 дүгээр захирамж, Газрын дүрмийн 7.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын соёл, шашны зан үйлийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлж, нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах зорилгоор “Даншиг наадам-Хүрээ цам” шашин, соёлын наадмыг Хүй долоо худагт 2023 оны 08 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд зохион байгуулсугай.


2. Наадмыг зохион байгуулахад шаардагдах 176,520,000 (Нэг зуун далан зургаан сая, таван зуун хорин мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.

3. Наадмыг арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (В.Батчимэг)-т даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ

115050012

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын  
2023 оны 08 дугаар сарын 01 өдрийн 139 дугаар  
тушаалын хавсралт



МОНГОЛЧУУДЫН ӨВ СОЁЛЫН “ДАНШИГ НААДАМ ХҮРЭЭ ЦАМ” НААДМЫН ТӨСВИЙН  
ЗАДАРГАА

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	2	4	5	6	8
1.	Монгол ахуйг харуулсан жуулчдад зориулсан гэр /2 өдөр түрээслэх	Ширхэг/өдөр	1*2	1,000,000	2,000,000
2.	Жуулчид хүлээн авах идээ засах /гэр дотор 2 өдөр/	багц	2	750,000	1,500,000
3.	Ажиллаж буй албан хаагчдын хоолны зардал 2 өдөр	Хүн/өдөр	02*/20	30,000	1,200,000
4.	Сайн дурын ажилтан 2 өдөр ажиллуулах	Хүн/өдөр	2*/20	60,000	2,400,000
5.	Хүрээ цам ба Майдар түүхэн гэрэл зургийн үзэсгэлэн	Багц/өдөр	1*/2	16,180,000	16,180,000
6.	Наадмын хөтөлбөр танилцуулга Англи, Монгол хэл дээр	ш	1000	1,000	1,000,000
7.	Ачааны машин түрээс /бэлтгэл ажлын эд хогшил зөөх	ш	5	400,000	2,000,000
8.	Асар майхан түрээс 2 өдөр	Ширхэг/өдөр	80*/2	150,000	24,000,000
9.	Тайз түрээс	багц	2	3,000,000	6,000,000
10.	Хаяг хөмсөг хийх	ш	100	21,000	1,102,000
11.	Харуул хамгаалалт 2 өдөр	Хүн/өдөр	2*/2	100,000	400,000
12.	Даншиг наадмын сурталчилгаа, шторк	багц	1	15,000,000	15,000,000
13.	Мандат хэвлэх /Зохион байгуулагч, Хүнс, худалдаа эрхлэгч, үйл ажиллагааны оролцогч,	ш	1000	1,000	1,000,000
14.	Мандатны уут	ш	1000	2,500	2,500,000
15.	Жуулчид монгол хувцас өмсөж зураг авхуулах орчин бүрдүүлэх /хувцас түрээс/	багц/өдөр	2	7,500,000	15,000,000
16.	Даншиг наадмын хөтөлбөрийг 10 байршилд хэвлэж тавих	ш	10	200,000	2,000,000
17.	Монгол үндэсний хоолны үзэсгэлэн, худалдаа	өдөр	2	3,500,000	7,000,000
18.	Морьт харвааны тэмцээн	багц	1	30,000,000	20,500,000
19.	Уухай шагайн харвааны тэмцээн	багц	1	30,000,000	30,000,000
20.	Сээр цохих тэмцээн	багц	1	9,950,000	9,950,000
21.	Тугны суурь	2	20	55,000	2,200,000
22.	Даавнуу дээр туг хэвлүүлэх	багц	20	99,000	1,980,000
23.	Эх бэлтгэл	ш	1	50,000	50,000
24.	Сандал	ш	1200*2	5,000	12,000,000
25.	<b>Нийт дүн:</b>				<b>176,520,00</b>

--o0o--